“МИКРОФИНАНС МОНГОЛИА ББСБ” ХХК

2022 оны санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1.Аудит хийж дууссан тухай тайлан

1.2. Аудитын тайлан дүгнэлт

1.1.1. Баланс

1.1.2. Орлогын тайлан

1.1.3. Өмчийн өөрчлөлтийн тайлан

1.1.4. Мөнгөн гүйлгээний тайлан

1.2. Аудиторын тайлангийн тодруулга

Аудитор: Б.Жаргалсайхан

Аудитор: А.Мөнхцэцэг

Утас: 99862066, 99041628

И-мейл: peakomaudit@gmail.com

Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг

Макс центр 405 тоот

1. АУДИТ ХИЙЖ ДУУССАН ТУХАЙ ТАЙЛАН

1. "Пийк ОМ Аудит "ХХК " Микрофинанс монголиа ББСБ " ХХК-ийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн "Микрофинанс монголиа ББСБ" ХХК-ийн 2022 оны Санхүүгийн тайланд аудит хийж тайлан дүгнэлтийг Хувь нийлүүлэгчдэд толилуулж байна.

Энэ тайлангийн

1-р хэсэгт Аудит хийж дууссан тухай, Аудитын тайлан дүгнэлт, аудиторын тайлангийн тодруулга

2-р хэсэгт Аудиторын зөвлөмж

Бид 2022 онд тайланд хийсэн аудитад дараахь зүйлсийг чухалчилж авч үзсэн:

- Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
- Дотоод хяналтын системээс гадна бидний анхааралд өртсөн асуудлууд

2. Хувь нийлүүлэгчдийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:
    1. Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх явцад илэрсэн зарим эрсдлүүдийн талаар толилуулсан
    2. Аудитын явцад илэрсэн зүйлс болон гаргасан шийдлүүдийн талаархи аудиторын санал бодлыг тусгасан
    3. Аудитын горимуудыг гүйцэтгэсний үндсэн дээр тус байгууллагын бэлтгэсэн санхүүгийн тайланд стандарт дүгнэлт өгч байна.

“ПИЙК ОМ АУДИТ” ХХК

Монгол улс, Дархан-Уул аймаг, Дархан сум,
10-р баг, Буудай центрийн 602 тоот
Tel: 9986-2066, 99041628
E-mail: peakomaudit@gmail.com

2023.03.09 №84

“МИКРОФИНАНС МОНГОЛИА ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “МИКРОФИНАНС МОНГОЛИА ББСБ” ХХК (“Компани”)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон Компанийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх хариуцлага” хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм”-ийн дагуу Компаниас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай дотоод хяналтыг бий болгох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу Компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасратлгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх хариуцлага

Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)
“МИКРОФИНАНС МОНГОЛИА ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн батлагаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрвээ тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”- ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

• Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдлийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боовсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэнд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдлээс өндөр байдаг.

• Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах

• Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх

• Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйлд явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрвээ материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл бидний олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

• Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлэх, мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

Бусад зүйл
Энэхүү тайланг Монгол улсын Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан ба өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИЙК ОМ АУДИТ ХХК

ЗАХИРАЛ **Б.ЖАРГАЛСАЙХАН**

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУДЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

/ МЯНГАН ТӨГРӨГӨӨР

/

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	Санхүүгийн тайлангийн дүн 2022.12.31	Аудит хийгдсэн дүн 2022.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,672.6	46,672.6
Зээл	2,419,497.8	2,419,497.8
Зээлийн эрсдэлийн сан	(478,262.7)	(478,262.7)
Бусад авлага / цэвэр/	426,738.3	426,738.3
Үндсэн хөрөнгө	53.3	53.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,414,699.3	2,414,699.3
Бусад өглөг	1,969.5	1,969.5
Нийт өр төлбөр	1,969.5	1,969.5
Хувьцаат капитал	2,230,000.0	2,230,000.0
Хандивын капитал		
Хуримтлагдсан ашиг	182,729.8	182,729.8
Эзэмшигчдийн өмчийн дүн	2,412,729.8	2,412,729.8
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,414,699.3	2,414,699.3

ОРЛОГЫН ТАЙЛАН

Хүүний орлого	131,434.0	131,434.0
Хүүний бус орлого	2,369.0	2,369.0
Арилжаа болон ханшийн тэгштгэлийн зардал		
Боловсон хүчний холбогдолтой зардал	29,676.0	29,676.0
Үйл ажиллагааны бусад зардал	26,972.3	26,972.3
Зээлийн эрсдэлийн зардал		
Үйл ажиллагааны бус орлого	107,420.9	107,420.9
Үйл ажиллагааны бус зардал		
Орлогын албан татвар	1,845.8	1,845.8
Татварын дараах цэвэр ашиг	182,729.8	182,729.8

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(282,218.6)	(282,218.6)
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(282,218.6)	(282,218.6)

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Хувьцаат капитал	2,230,000.0	2,230,000.0
Бусад өмч		
Хуримтлагдсан ашиг	182,729.8	182,729.8

АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

1.АУДИТЫН ЗОРИЛТ , ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад тус байгууллагын 2022 оны 12 сарын 31-ний байдлаархи баланс, орлогын тайлан, мөнгөн гүйлгээний болон өмчийн өөрчлөлтийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн баримт, холбогдох бусад материалуудыг хамруулж санхүүгийн тайлангийн тоо мэдээллүүд нь үнэн зөв гэдгийг баталгаажуулж , дүгнэлт өгөхөд аудитын үндсэн зорилго оршино.

Бид санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай хэмжээгээр дахин хянасан. Ийнхүү хянахдаа “Микрофинанс монголиа ББСБ ” ХХК-ийн дотоод хяналтын систем нь үр нөлөөтэй эсэх, санхүүгийн эрсдэл ба хяналтын талаархи өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас сэргийлэхийн тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

2.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг Монгол төгрөгөөр тайлагнасан.

НИЙЦЛИЙН МЭДЭГДЭЛ

ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн Стандартын Зөвлөл (НББОУС3)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын Стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

1. БАРАА МАТЕРИАЛ

ББСБ-ын бараа материалд үйл ажиллагаа явуулахад ашиглагдах бичиг хэрэг, хангамжийн материал орно.

2. ЭРСДЛИЙН УДИРДЛАГЫН ЗОРИЛТ БОЛОН БОДЛОГУУД

ББСБ-ынсанхүүгийн удирдлагын бодлого нь учирч болзошгүй сөрөг нөлөөг багасгахын тулд хүүний хувь, зээл ба төлбөрийн чадварын эрсдлүүдийг удирдахын

зэрэгцээ ББСБ-ын хөгжлийг дэмжих санхүүгийн зохистой баялагтай байх явдлыг баталгаажуулахыг зорьдог.

a) **Хүүний түвшний эрсдэл**
Хүүний түвшний эрсдэл нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн мөнгөн урсгал нь зах зээл дээрх хүүний түвшний хэлбэлзэлтэй холбоотойгоор үүсдэг. ББСБ нь тогтмол хүүтэй харилцах дансны үлдэгдэлд авсан тогтмол хүү байдаг учраас хүүний түвшний өөрчлөлтийн эрсдэлд өртдөггүй.

b) **Төлбөрийн чадварын эрсдэл**
ББСБ нь зээлийн бүх эргэн төлөлт хэвийн гэдгийг баталгаажуулахын тулд өөрийн зээл олгосон гишүүдийн зарцуулалт болон барьцаа хөрөнгийг идэвхитэй хянаж байдаг. ББСБ нь өөрийн төлбөрийн чадварын зохистой байдлын ерөнхий удирдлагын нэг хэсэг болгон, өөрийн гишүүдийн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг бэлэн байлгадаг.

3. САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮРҮҮДИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНЭ

Санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нэг бүрийн бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоход (эдгээр үнэ цэнийг тооцох нь практик дээр боломжтой бол) дараах арга төсөөллүүдийг ашигладаг.
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаат санхүүгийн хэрэглүүр учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.
Холбоотой талуудад өгөх өглөг: Холбоотой талуудад өгөх өглөгүүд нь хугацаагүй буюу хүссэн үед нь төлөх нөхцөлтэй учраас тэдгээрийн бүртгэлийн дүн нь бодит үнэ цэнэтэйгээ ойролцоо байдаг.

4. КАПИТАЛЫН УДИРДЛАГА

ББСБ-ийн үндсэн зорилго нь хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх явдал юм.

3. ІЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХУРААНГУЙ ТОДРУУЛГА

Мөнгөн хөрөнгө
/мян.төг/

Мөнгөн хөрөнгө	2021-12-31	2022-12-31
Банкинд байгаа мөнгө харилцах /төгрөг/	4,336.5	851.9
Банкинд байршиж байгаа хадгаламж / төгрөг/	324,554.6	45,820.7
Кассад байгаа мөнгө /Төгрөг/	00.0	
Дүн	328,891.2	46,672.6

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 46,672.6 мянган төгрөг болж өмнөх оноос 282,218.6 мянган төгрөгөөр бүурсан байна.

Зээл, зээлийн эрсдэл

Иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийг энэ дансанд тусгана. Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн хүүний хувь хэмжээг Монгол банкны хүүгийн бодлого, ББСБ-ын активаас олох орлого болон пассивт төлөх төлбөрийн дундаж хувь хэмжээ, үйл ажиллагааны зардал зэрэгтэй уялдуулан 0.5-3.0 хувиар тогтоохоор зээлийн үйл ажиллагааг зохицуулах журамд заасан байна.

Зээлийн үндсэн эрсдэл нь зээл болон урьдчилгаагаар дамжин үүсдэг. Энэ тохиолдолд зээлийн эрсдэлтэй дүн нь баланс дахь хөрөнгийн дансны үнээр илэрхийлэгдэнэ.

- 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,802,410.4 мянган төгрөгийн зээл нь хэвийн зээлд ангилагдсан байна.
- Зээл төлөгдөхөд учирч болзошгүй эрсдлээс хамгаалах нөөцийн түвшин дараах байдалтай байсан

	2022 он
Хугацаа хэтэрсэн зээл	5%
Хэвийн бус зээл	25%
Эргэлзээтэй зээл	50%
Муу зээл	100%

Үндсэн хөрөнгийн данс:

/мян.төг/

Үзүүлэлтүүд	2021.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2022.12.31
Тавилга, эд хогшил	246.0			246.0
Хуримлагдсан элэгдэл	168.1	24.6		192.7
Компьютер, дагалдах хэрэгсэл	4,155.6			4,155.6
Хуримтлагдсан элэгдэл	4,155.6			4,155.6

Тайлант онд үндсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй элэгдлийн зардлаар буурсан байна. Анхны өртөгөө элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийг цаашид ашиглахаар бол дахин үнэлгээ хийх, ашиглагдахгүй хөрөнгийг актлаж данснаас хасах шаардлагатай байна.

Бусад актив болон пассив

- Тайлант оны эцэст зээлийн хүүгийн авлага нь 417,972.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Богино хугацаат өр төлбөрт 1,969.5 мянган төгрөгийн өглөг нь татварын өглөг багтсан байна.

Орлого

- Хүүгийн орлого

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үндсэн зээл эсвэл хүү эргэн төлөгдөх нь эргэлзээтэй болсон үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхийг хойшлуулдаг. Монгол банкны шаардлагын дагуу хүүгийн төлбөр нь 90 хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоодог. Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосон үед холбогдох хүүгийн авлагыг данснаас хасч балансын гадуур бүртгэдэг. Хүүг хүлээн зөвшөөрсөнийг зогсоосоноос хойш хүүг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг. Эргэн төлөгдөх эргэлзээтэй байдал арилсан нөхцөлд хүүгийн орлогыг аккурэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

- Төлбөр хураамжийн орлого

Хэрэглэгчдэд үзүүлсэн санхүүгийн үйлчилгээндээ тэднээс төлбөр хураамж авдаг. Төлбөр хураамжийн орлогыг холбогдох үйлчилгээг үзүүлэх үед хүлээн зөвшөөрдөг.

/мян.төг/

Орлогын нэр төрөл	2022 он
Хүү болон түүнтэй адилтгах орлого	131,434.0
Хүүгийн бус орлого	2,369.0

Зардал */мян.төг/*

1.Боловсон хүчний холбогдолтой зардал	2022 он

Үндсэн болон нэмэгдэл цалин	26,400.0
Нийгмийн даатгалын шимтгэл	3,276.0
Дүн	**29,676.0**
2. Бусад үйл ажиллагааны зардал	
Аудитын үйлчилгээний зардал	1,000.0
Зээл болон авлагыг барагдуулахтай холбогдсон зардал	10,030.0
Автоматжуулалттай холбоотой зардал	4,488.5
Ашиглалтын зардал	891.9
Элэгдэл, хорогдолын зардал	24.6
Харуул, хамгаалалтын зардал	1,711.3
Түрээсийн зардал	6,000.0
Ариун цэврийн зардал	
Харилцаа холбоо интернет	575.1
Хэвлэл захиалгын зардал	
Зохицуулалтын үйлчилгээний хураамж	2,008.0
Бичиг хэргийн зардал	38.7
Зар сурталчилгааны зардал	204.2
Дүн	26,972.3

Тайлант онд хүүгийн болон хүүгийн бус орлогоор 133,803.0 мянган төгрөг орж 56,648.3 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны зардлын гүйлгээ,107,420.9 мянган төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч, 1,845.8 мянган төгрөгийн орлогын албан татвар тооцож 182,729.8 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна

Түс байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.